

ЭМНЕСТИ
ИНТЕРНЭШНЛ



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2021 ОН

**«НАМАЙГ СОНС»
ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨӨ
БИ ДУУГАРЧ БАЙНА**

ЭМНЕСТИ
ИНТЕРНЭШНЛ



БИД ХЭН БЭ?

Нобелийн шагналт Олон Улсын Хүний Эрхийн Эмнести Интернэшнл байгууллага нь Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал болон бусад баримт бичгүүдэд заасан хүний эрх, эрх чөлөөг хүн бүрт адил тэгш эдлүүлэхийн төлөө үйл ажиллагаа өрнүүлдэг дэлхий нийтийн томоохон хөдөлгөөн бөгөөд Монгол Улсад 1994 оноос эхлэн үйл ажиллагаагаа явуулж байна. Өнгөрсөн 28 жилийн хугацаанд бид кампанит ажлуудаар дамжуулан Монгол Улсын иргэдэд тэдний иргэний, улс төрийн, эдийн засгийн болон нийгэм соёлын эрхийг нь таниулах үйл ажиллагааг сургалт, олон нийтийн үйл ажиллагааны хэлбэрүүдээр зохион байгуулсаар ирсэн. Өнөөдөр Монгол Улсын хэмжээнд 7600 гаруй гишүүн, дэмжигчидтэй, нийслэл болон орон нутгийн, мэргэжил, сонирхлын 25 бүлэгтэйгээр ажиллаж байна.

ГИШҮҮД, ДЭМЖИГЧИД

1. Гишүүд дэмжигчдийг бүлгээр нь ангилбал



Нийт

7636



гишүүн



2021 онд

650

шинэ гишүүн



УДИРДАХ ЗӨВЛӨЛ



С. Ганчимэг
Удирдах зөвлөлийн дарга



Р. Очирбал
Удирдах зөвлөлийн дэд дарга



Б. Мөнхжавхлан
Санхүү хариуцсан гишүүн



Б. Болдсүрэн
ХЭБ хариуцсан гишүүн



Я. Мөнхчимэг
Кампанит ажил хариуцсан гишүүн



Б. Баялагмаа
Кампанит ажил хариуцсан гишүүн



Д. Оюунномин
Гишүүнчлэл хариуцсан гишүүн



Т. Жанерке
Хэвлэл мэдээлэл хариуцсан гишүүн



Б. Бадрал
Залуучууд хариуцсан гишүүн

ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛ



С. Очирбат
Хяналтын зөвлөлийн дарга



Б. Батцэцэг
Хяналтын зөвлөлийн гишүүн



М. Саруул-Эрдэнэ
Хяналтын зөвлөлийн гишүүн

ГҮЙЦЭТГЭХ ТОВЧОО



Б. Алтантуяа
Гүйцэтгэх захирал



Г. Амарзаяа
Кампанит ажил хариуцсан зохицуулагч



П. Мөнхжаргал
Кампанит ажил хариуцсан зохицуулагч



Т. Ариунаа
Санхүүгийн ажилтан 3 сар хүртэл



Т. Болорсүвд
Өсөлт, Хөгжил хариуцсан зохицуулагч 6 сар хүртэл



Г. Сүхбат
Өсөлт, Хөгжил хариуцсан зохицуулагч 6 сараас



Я. Цэцэнзаяа
Залуучууд, активизм хариуцсан зохицуулагч 4 сар хүртэл



Б. Тэргэл
Залуучууд, активизм хариуцсан зохицуулагч 4 сараас



У. Наранцацрал
Санхүүгийн ажилтан 3 сараас


ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛ



Зорилт.1 Гишүүд, дэмжигчид, малчид, иргэний нийгмийн байгууллагууд, олон нийтэд сургалт, хэлэлцүүлэг хийж, чадавхжуулах

"Философи-Хүний эрхийн уулзварт" Философийн Улсын олимпиад

- Философи-Хүний эрхийн уулзварт 12, 13 дахь олимпиадыг "Цар тахал ба Хүний эрх", "Зүй ёс ба Хүний эрх" сэдвийн хүрээнд тус тус цахимаар зохион байгуулав. Олимпиадад давхардсан тоогоор 22 их, дээд сургуулийн 110 оюутан оролцож, хүний эрхийн мэдлэгээ сорьлоо. Дархан-Уул, Орхон, Ховд аймгаас багууд оролцсон нь цахимаар зохион байгуулахын давуу тал байсан.



Эрхээ мэдье мэтгэлцээний тэмцээн

- Ковид-19-ийн халдварын улмаас 2021 оны Эрхээ мэдье мэтгэлцээний тэмцээний тэмцээнийг анх удаа цахимаар зохион байгууллаа. Тэмцээнд Дархан-Уул, Орхон, Архангай, Дорноговь аймаг, нийслэлийн 80 багийн 240 сурагч өрсөлдөв. Сурагчид мэтгэлцэхийн тулд тухайн хүний эрхийн асуудал болон түүний суурь шалтгааныг Эмнестигийн ном, гарын авлагаас суралцдаг нь бидний хүний эрхийн боловсрол түгээх нэгэн чухал суваг болжээ.



Эмнести Пресс хүний эрхийн цахим сонин

- Эмнестигийн залуу гишүүд Монголын анхны хүний эрхийн сар тутмын цахим сониныг эрхлэн гаргаж эхэллээ. 2021 онд цахим сонины 2 дугаар гарч, 130 гаруй хүнд хүний эрхийн мэдээлэл түгээжээ.

"Цар тахал ба Хүний эрх" Шог зургийн үзэсгэлэн

- Монголын шог зураачдын "Шогч бийр" холбоотой хамтарч "Цар тахал ба Хүний эрх" шог зургийн үзэсгэлэнг толилууллаа. Үзэсгэлэнд нийт 19 зураачийн 55 бүтээлийг дэлгэв. Үзэсгэлэнг "Хүний эрхийн Үндэсний форум"-ын үеэр төрийн ордонд мөн Хүүхдийн урлан бүтээх төвд 5 өдөр дэлгэж, 600 гаруй хүн үзэж сонирхжээ. Түүнчлэн, Шинэ эхлэл сургууль, мөн гишүүдэд цахимаар хүргэсэн нь нийт 1000 орчим хүнд хүрчээ.



Хүний эрхэд ээлтэй 9 сар /Sweet September/

- Бид илүү олон хүнийг хүний эрхийн төлөө дуугардаг, эрхээ мэддэг, эрхээ шаарддаг нийгмийг бүтээхийн төлөө гишүүдээ өргөжүүлдэг бөгөөд энэ жилийн хувьд цахим болон цахим бусаар Sweet September аяныг зохион байгуулж, 1500 гаруй хүнд хүний эрхийн боловсрол олгожээ.

Урлаг ба хүний эрх

- Урлагаар дамжуулан иргэд олон нийт, хүүхэд багачуудад хүний эрхийн боловсрол олгох зорилгоор Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн "Экстрем спортын талбай"-н 12 ханыг зурж тохижууллаа. Ингэснээр хүүхдүүд спортоор хичээллэнгээ хүний эрхийг сонирхох үзүүлэн болжээ.



Зорилт.2 Хүний эрхэд ээлтэй сургууль хөтөлбөрийн сургуулиудыг дэмжих, хөтөлбөрийг түгээн дэлгэрүүлэх

Эмнести Интернэшнлийн “Хүний эрхэд ээлтэй сургууль” хөтөлбөр нь сургуулийн удирдлага, харилцаа, сургалтын хөтөлбөр болон сургуулийн орчин зэрэг сургуулийн бүх үйл ажиллагаанд хүний эрхийг дээдэлсэн бодлого, дүрэм, журам гаргаж, хамтаараа хэрэгжүүлснээр хүний эрхийн соёл, хандлага төлөвшүүлэх зорилготой юм. Хөтөлбөрт нийслэл, Орхон, Дархан-Уул, Булган аймгийн нийт 20 гаруй сургууль нэгдэн ажиллаж байна.

- Хүний эрхэд ээлтэй сургууль хөтөлбөрийн сургагч багшийн цахим сургалтууд, Ковид-19 ба Хүний эрх зэрэг сургалтууд багш нарыг идэвхжүүлж, тэд хүний эрхийн үйл ажиллагааг сургууль, хамт олон, сурагчдадаа явуулах нь ихэссэн.
- ХЭЭС-ийг танилцуулах уулзалт, зурагт хуудас, подкаст ярилцлага зэрэг цахим контент бэлтгэн нийгмийн сүлжээгээр түгээсэн. Ингэснээр хөтөлбөрийг сонирхох, мэдээлэл авахыг хүссэн сургууль, багш, холбогдох боловсролын байгууллагууд нэмэгдэв.
- Тэнцэтгэлийг өөрчилье - “Нөхөрсөг жаалууд” цахим болон танхимын сургалтыг Сэлэнгэ, Завхан, Баян-Өлгий, Дархан-Уул, Орхон аймгийн сурагчдад хийж, 4200 сурагчийг хамруулсан. Танилцуулга хэвлэж, зурагт хуудас гарган нийгмийн сүлжээгээр мөн Ньюс чаннел телевизээр мэдээлэл өгснөөр сургалтын захиалга нэмэгдэж, сургалтын эрэлт, хэрэгцээ нийгэмд их байгааг харуулсан.



Хүний эрхийг ээлжит хичээлийн хөтөлбөрт нэгтгэх нь

- Олон улсын хүний эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан “Хүний эрхийг ээлжит хичээлийн хөтөлбөрт нэгтгэх нь” нээлттэй хичээлийн уралдааныг ХУД-ийн Боловсролын хэлтэс, ЕБ-ын 118-р сургуультай хамтран цахим болон танхимын хэлбэрээр зохион байгуулав. Нийслэл, Орхон, Ховд аймгийн 38 багш түүх, нийгмийн ухаан, эрүүл мэнд, монгол, англи, орос хэл, физик, математик, мэдээлэл зүй, биологийн хичээлд хүний эрхийг тусган нээлттэй хичээл зааж өрсөлдсөн нь сайн хичээлийн санг 38 ээлжит хичээлээр нэмэгдүүлэв.



Хүний эрхийн боловсролын бусад ажил

- Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх Үндэсний хөтөлбөрийн 2021 оны төлөвлөгөөний дагуу хөтөлбөрийн 3 зорилтын 14 зүйлээр ХЭБ олгох үйл ажиллагаагаа зохион байгуулав.
- Эмнести Интернэшнлийн хүний эрхийн боловсрол олгох ном, товхимол, гарын авлага, судалгааг ESAN цахим номын санд байршуулж, олон нийтийг цахимаар судлах боломж бий болголоо.
- Өмгөөллийн Фединтас Партнерс ХХН-ийн бэлтгэн гаргадаг “Эрхээ эдэлье” подкасттай хамтран ажиллаж, олон нийтэд мэдээлэл хүргэлээ.



135

Багш, сурган хүмүүжүүлэгч




4550

оюутан, сурагч үйл ажиллагаанд оролцож



220,000

гаруй иргэнд
хүний эрхийн боловсрол олгожээ.

38

Сайн хичээлийн сан
нэмэгдүүлжээ.



ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨ



Зорилт.1 Үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг бэхжүүлэх

- 2021 онд иргэдийн зүгээс жагсаал, цуглаан, өлсгөлөн, суулт зэрэг уламжлалт арга хэрэгсэл болон флаш моб, иргэний үл захирагдахуй, хөдөлмөрийн багаж, хэрэгслийн цуглаан, цахим цуглаан, нэг хүний суулт зэрэг олон арга хэлбэрээр өөрсдийн үзэл бодол, санал, шаардлагыг нийтэд илэрхийлж, тайван замаар жагсаж, цуглах нь өмнөх онуудаас илүү нэмэгдлээ.
- Өмгөөллийн Фиделитас Партнерс ХХН-тэй хамтран Нийтийн мэдээллийн тухай хуулийн төсөл, Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хуулийн төслүүдэд мэдээлэл авах эрх, хувийн нууцтай байх эрхийн талаарх олон улсын хууль, хэм хэмжээнд нийцэж байгаа эсэх талаар дүн шинжилгээ хийв.
- УИХ-аас боловсруулан гаргаж байгаа хуулиуд нь хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулсан байхыг шаардаж, “Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөл”-д санал боловсруулан УИХ-ын гишүүдэд хүргүүлээ. Уг саналд хувь хүний халдашгүй байх эрх-мартагдах эрх, хүүхдийн хувийн мэдээллийг хамгаалахтай холбоотой үүсэж буй харилцааг зохицуулах, хувийн нууцад халдах техник, үйлдлийн системүүдийг ашиглахаас зайлсхийх, технологи эзэмшигч болон технологи ашиглан үйлчилгээ үзүүлэгч хувийн хэвслүүд хүний эрхийг хүндэтгэх, хэрэглэгчийнхээ хувийн нууцтай байх эрх, үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хүндэтгэх тухай, энэ үүргийг нь хуулиар баталгаажуулахыг шаардлаа.
- Оюутан, залуучуудын бүлгийн гишүүд “Нууц шүү за” хувийн нууцаа хамгаалах цахим аяныг эхлүүлэн, “Хувийн нууцаа хамгаалъя” гарын авлага, видео контент, подкаст, мэдээ, мэдээллээр дамжуулан олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэв.



Зорилт.2 Бүх нийтийн тайван цугларах эрхийг баталгаажуулах

- Иргэдээс үзэл бодлоо илэрхийлж, засгийн газрыг шүүмжилж, тайван замаар жагсаал цуглаан зохион байгуулсан, оролцсон иргэдийн хууль ёсны эрхийг үндэслэлгүй хязгаарлаж, баривчилж хорьсон, заримыг нь өмгөөлүүлэх эрхээр хангаагүйгээр цагдан хорих шийтгэл оногдуулсан зэргээр шударгаар шүүлгэх эрхийн олон улсын хэм хэмжээг зөрчсөн талаарх гомдол, мэдээллийг бидэнд ирүүлсээр байна.
- Нээлттэй Нийгэм Форумтай хамтран зохион байгуулсан “Ковид 19 цар тахлын үеийн хууль сахиулах ажиллагаа: Жагсаал, цуглаан” сэдэвт хэлэлцүүлэгт Хүний Эрхийн Үндэсний Комисс, Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Холбоо, Глоб Интернэшнл, судалгааны байгууллага, иргэдийн төлөөлөл нийт 60 орчим хүн оролцлоо. Хэлэлцүүлгийн оролцогчид цар тахлын үед иргэдийн зохион байгуулсан халдвар хамгааллын дэглэмээ сахиж, хүн хоорондын зайгаа барьсан тайван жагсаал цуглааныг албадан тарааж, үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хэтрүүлэн хязгаарлаж байгааг онцоллоо.
- Төрийн холбогдох байгууллагаас үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хэтрүүлэн хязгаарлаж, хууль сахиулагчдын зүгээс тайван замаар явагдаж байгаа жагсаал цуглааныг тарааж, иргэдийг баривчилж, хорьж байгаад Монголын Эмнести Интернэшнл гүнээ харамсаж байгаагаа илэрхийлж, мэдэгдэл гаргалаа. Уг мэдэгдэлд тайван замаар жагсаал цуглаан зохион байгуулж, эсхүл түүнд оролцох явцдаа баривчлагдан, цагдан хоригдож байгаа бүх хүнийг зохих ёсны процедурын дагуу шударгаар шүүж, гэм буруугүй нь тогтоогдвол яаралтай, ямар ч болзолгүйгээр суллахыг шаардлаа.

"НУУЦ ШҮҮ ЗА" АЯНЫ МЭДЭЭЛЭЛ



1,000,000

гаруй хүнд хүрчээ.

ЭДИЙН ЗАСАГ, НИЙГЭМ, СОЁЛЫН ЭРХИЙГ ХАМГААЛАХЫН ТӨЛӨӨ



ОРОН БАЙРТАЙ БАЙХ ЭРХ

Зорилт.1 Хуулийн хамгаалалтыг бий болгох

- “Эрх зүйн хөтөч нар – орон байртай байх эрх, нүүлгэн шилжүүлэлт” Фэйсбүүк пэйжийг 22 эрх зүйн хөтөч тогтмол ажиллуулж, 3500 мэдээ, зурагт хуудас оруулж, 101814 хүнд хүрчээ. Пэйжийг 1300 гаруй хүн дагаж, мэдээлэл авдаг болсон байна.
- Эрх зүйн хөтөч нарыг идэвхжүүлэх “Хуулиа уншъя” цуврал цахим сургалт зохион байгуулж, хөтөч нарыг иргэдэд хуулийг энгийн үгээр тайлбарлах, ойлгуулахад чадавхжууллаа.
- Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн талаар 7 тайлбар бичил видеогоор 1650 хүнд, Орон байртай байх хүний эрхийн тухай 7 подкаст ярилцлагаар 3200 хүнд, “Хотын хөгжил-Дахин төлөвлөлт-Орхигдсон иргэд” хэлэлцүүлгийг шууд цацаж, хэлэлцүүлгийн илтгэлүүдээр 3 бичил видео хийсэн нь 200,000 хүнд хүрчээ.

Зорилт.2 Эрхээ мэддэг, хамгаалдаг, шаарддаг соёлыг бий болгох

- Нээлттэй нийгэм форумын дэмжлэгтэйгээр Орон байртай байх эрхийн эрх зүйн хөтөч төслийн хүрээнд нийт 22 эрх зүйн хөтөч Архангай, Завхан аймаг, нийслэлийн БЗД-т иргэдэд эрх зүйн анхан шатны зөвлөгөө тэр дундаа Орон байртай байх эрхийн зөвлөгөө, мэдээлэл өгөх байнгын ажлын байр ажиллуулахын зэрэгцээ сургалтаар 30 сургагч багш бэлтгэв. ХУД, БГД, СБД, ЧД-т иргэдийн гэрээр, захиалгаар явж, утсаар, цахимаар зөвлөгөө өгдөг явуулын эрх зүйн хөтөч нар ажиллаж, 1500 орчим хүнд хүрсэн байна.
- Эрх зүйн хөтчийн үйл ажиллагааг БЗД-ийн ЗДТГ-ын Иргэдэд үйлчлэх нэг цэгийн үйлчилгээнд нэгтгэн, иргэдэд зөвлөгөө мэдээлэл өгсөн нь 350 хүнд хүрсэн.
- БЗД-ийн ЗДТГ-тай хамтран 28 хорооны 800 төрийн албан хаагчид орон байртай байх эрх болон хүний эрхийн 5 өдрийн цогц сургалтыг цахимаар явуулснаар 22 хорооны давхардсан тоогоор 705 хүнийг хамруулав.

- ХУД-ийн 5, 8-р хорооны иргэдэд зориулсан гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд орон байртай байх эрхийг хамгаалах тухай хичээл, хэлэлцүүлгийг ФБ лайваар 6050 хүнд түгээжээ. Энэ нь зорилтот бүлэгт хэрэгтэй мэдээллийг түргэн, шуурхай түгээх арга болж, хэрэглээнд нэвтэрсэн.
- Өмгөөллийн Федилитас партнес ХХН-тэй хамтран гэр хорооллын дахин төлөвлөлтөд хамрагдан хохирч, 2014 оноос хойш орон гэргүй яваа иргэнд Про-боно өмгөөлөл хийлгэснээр уг иргэнийг түр орон сууцаар хангагдах эрхтэй болохыг тогтоосон анхан шатны шүүхийн шийдвэр гарсан нь төрөөс орон байртай байх хамгаалсан, хүлээн зөвшөөрсөн явдал болсон.
- Дамбадаржаа дэд төвийн бүтээн байгуулалтын газар нутагт хамрагдсан иргэдэд хууль, эрх зүйн зөвлөгөө өгснөөр тэд нөхөх олговрын асуудлаар АХБ-нд гомдол гаргажээ. Гомдлын мөрөөр 358 өрх тус бүр 1-12 сая төгрөгөөр нөхөх олговроо нэмүүлж чадсан байна.
- БЗД-ийн 10-р хорооны Хангамжийн 27 айл эвлэлдэн нэгдэж, нөхөх олговор, түр суурьших орон байр санал болгосон өрх бүрт зориулсан нарийвчилсан төлөвлөгөөг төсөл хэрэгжүүлэгчээс шаардсан, нийслэл болон БЗД зэрэг холбогдох газраас баталгаа нэхсэн уулзалтууд зохион байгуулж, холбогдох газруудад гомдол гаргасан. Энэ нь тухайн иргэд эрх зүйн зөвлөгөө авснаар илүү их хохирохоос сэргийлж чадсан байна.



30

Сургагч багш бэлтгэж

Цахимаар:



7

подкаст



705

Төрийн албан хаагч



7

Хууль тайлбарласан бичлэг



1500

иргэн зөвлөгөө авав.



312,714

Хүн мэдээлэл авчээ.

КОВИД-19 БА ХҮНИЙ ЭРХ

Зорилт.1 Ковид-19-ийн үед иргэдийн эрүүл байх эрхийг хамгаалах

Ковид-19 ба Хүний эрхийн боловсрол

- Цар тахлын эсрэг арга хэмжээ авах явцад хүний эрхийн зөрчил байгаа нь төрийн албан хаагчдын хүний эрхийн талаарх мэдлэг, ойлголт дутмаг байгаатай шууд холбоотой талаар бид олон нийтэд мэдэгдэл гаргасан. Мэдэгдлээр Засгийн газарт “Төрийн албан хаагчдад хүний эрхийн талаарх ойлголт, мэдлэг, хандлага төлөвшүүлэх тусгай хөтөлбөр баталж, төрийн өндөр албан тушаалд нэр дэвшигч нарт тус сургалтад хамрагдсан байх шалгуур тавих” зөвлөмж хүргүүлж, үр дүнтэй арга хэмжээ авч ажиллахыг уриалсан. Мэдэгдлийн хүрээнд “Монгол Улсын иргэн би шийдвэр гаргагчдад хүний эрхийн боловсрол олгохыг шаардаж байна” цахим аян гишүүдийн дунд өрнүүлээ.
- “Ковид-19 ба Хүний эрх” цахим сургалтыг Монгол хэлээр Эмнести Интернэшнлийн цахим талбарт байршуулаад байна.



Ковид-19 ба Хүүхдийн эрх

- Ковид-19 цар тахлын нийгэм-эдийн засгийн сөрөг үр нөлөө болон хүүхдийн цахим орчин дахь аюул, эрсдэлийг бууруулах арга хэмжээ авах талаар Засгийн газарт, Хүүхдийн төлөө Үндэсний зөвлөлийн гишүүн байгууллагуудад зөвлөмж хүргүүлсэн. Боловсрол, шинжлэх ухааны яамнаас ирүүлсэн албан бичигт бидний өгсөн санал, зөвлөмжийг бодлого, шийдвэртээ тусган хэрэгжүүлнэ гэдгээ албан бичгээр мэдэгдлээ.

Зорилт.2 Эмч, эмнэлгийн ажилтны эрхийг хамгаалах

Ковид-19 ба эмч, эмнэлгийн ажилтны эрх

- Эмч, эмнэлгийн ажилтнуудын эрүүл байх, хөдөлмөрлөх эрхийг хангах тухай цахимаар мэдээлэл хүргэж, 54 контент бэлтгэжээ.
- “Эмч, эмнэлгийн ажилтнуудад захидал бичиж, урам хайрлацгаая” захидал бичих аян ЕБС-ийн багш, сурагчдын дунд өрнүүлсэн.



Ковид-19 ба Вакцин

- Вакцинтай холбоотой мэдээлэл, видео контент, яаралтай үйл ажиллагаанд нэгдэх зэргээр цахим, цахим бусаар гишүүд, дэмжигчидтэй хамтран ажилласан.

Б.Алтантуяа: Вакцин тойрсон асуудалд хүний эрхийн үүднээс хандах ёстой

Мягмаржаргал Д

2021-09-08



580

захидал



58

цахим контент



7800

Хүнд хүрчээ.

Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн бусад ажил

- Эмнести Интернэшнлээс Азийн хөрөнгө оруулалтын дэд бүтцийн банк /АХОДББ/-ны Байгаль орчин, нийгмийн хүрээ албан бичгийн шинэчлэн боловсруулах төслийг хянан хэлэлцэхэд оролцож, саналаа өгснийг Монголын Засгийн газарт, холбогдох салбарын 10 сайдад хүргүүлсэн. Зам тээврийн хөгжлийн яам Дархан чиглэлийн хатуу хучилттай автозамын нэг хэсгийг Европын сэргээн босголт хөгжлийн банкны санхүүжилтээр гүйцэтгэх бөгөөд ингэхдээ бидний өгсөн зөвлөмжийг гэрээндээ тусган хэрэгжүүлж эхэлснээ мэдэгдсэн байна.
- Эмнестигийн АХОДББ-д өгсөн санал болон Монгол Улсын Бизнес ба Хүний эрхийн үндэсний хөтөлбөр боловсруулах ажлын явцыг танилцуулах, Олон улсын хөгжлийн банкуудын Байгаль орчин, нийгмийн хамгааллын бодлого, Гомдол барагдуулах механизмын хэрэглээний талаар мэдээлэл өгөх “Бизнес ба Хүний эрх” хэлэлцүүлэг зохион байгуулав. Хэлэлцүүлэгт холбогдох төрийн болон олон улсын 20 орчим байгууллага, судлаачид, Бизнес ба Хүний эрхийн үндэсний хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийг урьж оролцуулав.
- Эх дэлхийн өдрийг угтан Бельгийн Эмнестигийн санаачилж буй баримтат кинонд Эмнестигийн залуучууд оролцож, Монгол Улсын хувьд тулгамдаж буй асуудал, түүний шийдлийн талаар дуу хоолойгоо өргөж, эв санааны нэгдлээ илэрхийлэв.
- Ирээдүй хойчийн эрх, Эх дэлхийн өдөр, Усны өдөр, Уур амьсгалын өөрчлөлт, Байгаль орчныг хамгаалах сэдвийн хүрээнд олон нийт, гишүүдэд мэдээлэл өгөх зурагт хуудас бэлтгэн цахим/цахим бусаар түгээсэн.
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор Олон улсын хүний эрхийн өдрийг тохиолдуулан Хүний эрхийн Үндэсний комиссын зохион байгуулсан “Хүний эрхийн Үндэсний Форум”-ын “Эдийн засаг, нийгмийн эрх”, “Уур амьсгалын өөрчлөлт ба Хүний эрх” салбар хуралдаанд оролцож, Эмнести Интернэшнлийн байр суурийг илэрхийлж, чуулганы зөвлөмжид санал өгөв. Чуулганы үер “Төсөв, Мөнгө, Хүний эрх” гарын авлагыг оролцогчид түгээлээ.



ХҮНИЙ ЭРХ ХАМГААЛАГЧИЙГ ХАМГААЛАХ НЬ



Дэлхийн өнцөг булан бүрт
хүний эрх хамгаалагч бий



Зорилт.1 Хүний эрх хамгаалагчийн үйл ажиллагааг хүлээн зөвшөөрүүлэх, аюулгүйгээр шударга бусын эсрэг тэмцэх эрх зүйн орчин бий болгох

2021.04.02

МОНГОЛ УЛС ХҮНИЙ ЭРХ ХАМГААЛАГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ БАТАЛЛАА

Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай үр нөлөө бүхий хууль эрх зүйн орчин бий болгохыг шаардан дараах үйл ажиллагааг өрнүүллээ. Үүнд:

- Монголын Эмнести Интернэшнлээс Хүний Эрхийн Үндэсний Комисс, хүний эрхийн ТББ-ын Форум болон бусад иргэний нийгмийн идэвхтэн тэмцэгчид, хуульч, судлаачдын хамтаар цахим болон танхимаар хэлэлцүүлэг, сургалт, нөлөөллийн уулзалтууд зохион байгуулж, хуулийн төслийг сайжруулах чиглэлээр санал, шүүмж, уриалга гаргаж, цахимаар болон хэвлэмэлээр хууль тогтоогчдод хүргэлээ.
- Хүний эрх хамгаалагчдын талаарх үр нөлөө бүхий хууль эрх зүйн орчин бий болгохыг шаардсан зурагт хуудас, видео бичлэг, хэвлэлийн мэдээ, уриалгыг гишүүд дэмжигчдийн хамт цахим орчинд өрнүүллээ.
- “Хүний эрх хамгаалагчдыг хүлээн зөвшөөрөх, хамгаалах тухай загвар хууль”-ийг орчуулан гаргаж бусад олон улсын баримт бичиг, хүний эрх хамгаалагч Монгол идэвхтэн тэмцэгчдийн түүхийн хамт УИХ-ын гишүүдэд хүргүүлээ.
- Хүрээлэн буй орчин, хүүхэд эмэгтэйчүүд, болон бусад хүний эрхийг хамгаалах үйл ажиллагаа өрнүүлж байгаа хүний эрх хамгаалагчид идэвхтэн тэмцэгчдийн түүхийг www.amnesty.mn сайтад байршуулж, МҮОНП-оор орон нутгийн сонсогчдод сонордуулав.



- Монголын эрэн сурвалжлах сурвалжлагчдын төлөө төв, Оюу толгойн хяналт ТББ-тай хамтран 2021 оны 2-3 сард сэтгүүлч нийтлэлч, чөлөөт уран бүтээлчдийн дунд “Хүний эрх хамгаалагч зоригтон” хөрөг найрууллын уралдааныг 3 дахь жилдээ зохион байгуулж, олон нийтийн хүний эрх хамгаалагчийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэв.
- Уралдааны оролцогчдын радиогийн 7, сонин хэвлэлийн 15, нийт 22 бүтээл байгаль орчин, орон байртай байх эрхийн төлөө тэмцэгч зэрэг хүний эрх хамгаалагчдын түүхийг өгүүлж, вэб сайт, өдөр тутмын сонин, радио подкастаар олон нийтэд хүрэв.

Хүний эрхийн зөрчилд шуурхай хариу үзүүлэх Тусгай төсөв

- Хүний эрхийн ТББ-ын Форумын дэргэд хүний эрхийн зөрчилд хариу үзүүлэх, мониторинг, стратегийн өмгөөлөл хийх, хүний эрх хамгаалагчдыг хамгаалах зорилготой тусгай төсвийг үүсгэж, үйл ажиллагааг эхлүүлээд байна.

Зорилт.2 Хүн бүр хүний эрхийг дээдэлдэг дэлхий ертөнцийг бүтээхэд залуучуудын идэвх оролцоог нэмэгдүүлэх

- “Залуу хүний эрх хамгаалагч” зуны цахим сургалтаар Улаанбаатар хотын 15, орон нутгийн 11 сурагч, оюутнуудад хүний эрхийн мэдлэг, боловсрол олголоо.
- Цахим сургалтаар 50 орчим сэтгүүлч, нийтлэлчдийн хүний эрх хамгаалагчид, тэдний түүхийг хэрхэн бичих талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлээ.
- Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль, хүний эрх хамгаалагчдын хөрөг найруулал, кампанит ажлын талаарх мэдээ мэдээлэл олон нийтэд цахимаар 100,000 гаруй хүнд хүрчээ.



50

Сэтгүүлч



26

залуу манлайлагч

ЭРҮҮДЭН ШҮҮХИЙГ ЗОГСООЁ



Зорилт.1 Монгол улсад Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн нэмэлт протоколын дагуу үр нөлөө бүхий Үндэсний урьдчилан сэргийлэх механизм байгуулахад нөлөөлөх

- Монголын Эмнести Интернэшнлээс олон нийт, гишүүд, дэмжигчдэд эрүүдэн шүүхээс ангид байх эрхийн талаарх мэдлэг ойлголт өгөх сургагч багш нарыг бэлдлээ. Сэлэнгэ аймгийн сум дундын прокурорын газартай хамтран прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчид, сургуулийн багш, нийгмийн ажилтнуудад сургалт явуулж, хүний эрх, эрүүдэн шүүхээс ангид байх эрхийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэв.
- Эмнести Интернэшнлээс 2021 оны 5-р сарын 12-нд Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль нь хүний эрхийн санаа зовоосон ялангуяа засгийн газрын үйл ажиллагааг шүүмжилсэн иргэдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хэт хязгаарласан нөхцөл байдалд болох гэж байгааг сануулсан мэдэгдлийг гаргаж, сонгуулийн өмнө эсвэл дараа нь хүмүүсийг баривчилж, хорьж болзошгүй хэмээн санаа зовниж байгаагаа илэрхийллээ.
- Нээлттэй Нийгэм Форумын дэмжлэгээр хэрэгжүүлсэн “Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээний хүрээнд цагдаагийн албаны үйл ажиллагаанд мониторинг хийх нь” төслийн хүрээнд хүний эрхийн зөрчлийг баримтжууллаа. Бид Цагдаагийн газар, үйлдвэрчний Эвлэл, Хүний Эрхийн Үндэсний Комисс, Глоб Интернэшнл, Дотоод хэргийн их сургуулийн сонсогчид зэрэг холбогдох байгууллага, албан тушаалтан, хуульчид, судлаачид, иргэний нийгэм, хүний эрхийн ТББ-ууд, иргэдтэй уулзалт ярилцлага, ТВ-ийн мэдээ, өдөр тутмын сонин хэвлэлд мониторинг хийж, мэдээ мэдээллийг цуглуулан, дүн шинжилгээ хийлээ.

Зорилт.2 Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс урьдчилан сэргийлэх

- Төслийн хүрээнд олж цуглуулсан мэдээ, баримтуудыг олон нийтэд түгээх, баримтжуулах чиглэлээр цуврал хэлэлцүүлгийг цахимаар зохион байгууллаа. “Ковид 19 цар тахлын үеийн хууль сахиулах ажиллагаа: Хүч, тусгай хэрэгсэл” сэдвийн хүрээнд зохиогдсон хэлэлцүүлэгт оролцсон илтгэгчид, оролцогчдын зүгээс хууль сахиулах алба хаагчид ковид цар тахлын үед хэв журам сахиулах, хязгаарлалтын дэглэм мөрдүүлэх явцдаа хүчийг хэтрүүлэн хэрэглэж, хүний халдашгүй байх эрхийг зөрчсөн талаар дурдлаа.
- Хүний Эрхийн Үндэсний Комисс, Цагдаагийн Ерөнхий газартай хамтарсан уулзалт хийж, цагдаагийн алба хаагчдын хүний эрх, ялангуяа эрүүдэн шүүхээс ангид байх, жагсаал цуглааны үеэр хэв журам сахиулахдаа хүний эрхийн хэм хэмжээг баримтлан ажиллах талаарх мэдлэг ойлголтыг нь нэмэгдүүлэх цогц сургалтын хөтөлбөр боловсруулах, сургагч багш бэлтгэх хэрэгцээ шаардлага байгааг тодорхойллоо.
- Ийгл ТВ-ийн Зочны цагаар оролцон эрүүдэн шүүхээс ангид байх эрхийн хэрэгжилт хангалтгүй байгааг дурдаж, эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх хүрээнд төрийн албан хаагчдад хүний эрх, эрүүдэн шүүхээс ангид байх эрхийн талаарх мэдлэг ойлголтыг өгөх сургалтыг тогтмол системтэйгээр зохион байгуулах шаардлагатайг онцоллоо.



Эрүүдэн шүүхээс ангид байх эрхийн талаарх постер, мэдээ мэдээлэл цахимаар



140,000

хүнд хүрчээ

ЭРСДЭЛД БУЙ ХҮМҮҮС



Зорилт: Эрсдэлд буй хувь хүн, хүний эрх хамгаалагчдыг хамгаалах үйл ажиллагааг бэхжүүлэх, гишүүд дэмжигчдийг идэвхжүүлэх

ТАНЫ ҮГ ХҮЧТЭЙ

Эрх нь зөрчигдсөн нэгний төлөө цөөхөн ч гэсэн хүн нэгдэн үйл ажиллагаа өрнүүлэх нь гайхмаар үр дүн авчирдаг.

2020 ОНД ЭРХИЙНХЭЭ ТӨЛӨӨ БИЧИЦГЭЭЭ АЯНЫГ ДЭМЖИГЧИД ДЭЛХИЙН ӨНЦӨГ БУЛАН БҮРЭЭС НИЙТЛЭГ НЭГ ЗОРИЛГЫН ДОР НЭГДЭЖ 4,5 САЯ ЗАХИДАЛ БИЧИЖ, ТВИТЕРЭЭР ЖИРГЭЖ, ҮЙЛ АЖИЛЛАГАА ӨРНҮҮЛЖЭЭ.

- Эмнести Интернэшнлийн Эрхийнхээ төлөө бичигцгээе 2020 үйл ажиллагааны үр дүнд Хирак эсэргүүцлийн хөдөлгөөний талаар бичсэнхээ төлөө 2 жилийн хорих ял сонсоод байсан Алжирын сэтгүүлч Халед Драрени суллагджээ.
- Эмэгтэйчүүдийн эрхийн төлөө тэмцэгч Нассима аль-Сада тайван замаар хүний эрхийг хамгаалсныхаа төлөө 2018 онд баривчлагдсан юм. Дэлхийн өнцөг булан бүрээс дэмжигчид 777611 захидал бичиж, твиттерээр жиргэж, үйл ажиллагаа өрнүүлсний үр дүнд Нассима 2021 оны 6 дугаар сард суллагдаж, гэр бүл найз нөхдөдөө эргэн иржээ.
- Бурунди улс 2018 оны 4-р сард хүний эрх хамгаалагч Жермейн Рукуид хилс хэргээр 32 жилийн хорих ял оногдуулжээ. Жермейний төлөө 400 000 захидал, зурвас илгээгдсэний үр дүнд түүнийг 2021 оны 6 дугаар сарын 30-нд суллажээ.
- Монголын Эмнести Интернэшнлийн гишүүд дэмжигчид Афганистан улс дахь зэвсэгт мөргөлдөөний үеэр Хазара иргэдийн амь насыг хохироосон хэрэгт хариуцлага тооцох, Афганистан улс дахь энгийн иргэдийн аюулгүй байдлыг хамгаалахыг шаардсан уриалгад нэгдэв.

ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛИЙН ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТАЙЛАН 2020/21:

- Эмнести Интернэшнлээс жил бүр улс орнуудын хүний эрхийн нөхцөл байдлын талаар тайлан эмхтгэн гаргадаг. Уг тайланд Монгол улсад Ковид-19 цар тахлын тархалтаас урьдчилан сэргийлэх хөл хорио тогтоох, тусгаарлах арга хэмжээ нь гэр бүлийн хүчирхийллийг нэмэгдүүлж, хүүхдийн сурах, эрүүл байх эрхэд сөргөөр нөлөөлж, 6 дугаар сард болсон УИХ-ын сонгуулийн өмнө засгийн газрыг шүүмжилсэн хүмүүсийг дур зоргоор баривчлах тохиолдол нэмэгдэж, эрүүдэн шүүсэн хэргийг мэдээлдэггүй, хариуцлага тооцдоггүй байдал үргэлжилсээр байгааг онцоллоо.

ЭРХИЙНХЭЭ ТӨЛӨӨ БИЧИЦГЭЭЭ АЯН:

- 2021 оны 12-р сарын 1-25-ны хооронд үргэлжилсэн Эрхийнхээ төлөө бичигцгээе аяны үеэр гишүүд дэмжигчид Хятад, Тайланд, Гватемал, АНУ, Украин улсад эрх нь зөрчигдсөн хувь хүмүүсийн төлөө гарын үсэг зуруулах үйл ажиллагаа өрнүүллээ. Оюутан залуучууд, сурагчдын бүлгийн гишүүд энэхүү захидал уриалгын аяныг Шихихутуг ХЗС, МУИС-ийн ХЗС, АШУИС дээр, Завхан, Орхон аймгийн бүлгийн гишүүд аяны үйл ажиллагааг орон нутагтаа зохион байгуулж, эрсдэлд буй хувь хүн, бүлэг хүмүүсийн эрхийг хамгаалахыг шаардлаа.



ЭРХИЙНХЭЭ ТӨЛӨӨ БИЧИЦГЭЭЭ АЯН



3400

ил захидал, цахим гарын үсэг илгээж



15,000

хүнд мэдээлэл, видео контентууд хүрчээ

БАЙГУУЛЛАГЫН ӨСӨЛТ, ХӨГЖИЛ



Зорилт.1

Өөрсдийн нөөц бололцоо, оролцоог хамгийн дээд түвшинд хүргэх

1. Гишүүд болон олон нийтийн оролцоо



321



9113




805,238

Үйл ажиллагаа

ИДЭВХТЭН

ДЭМЖИГЧ



2. Удирдлага, манлайлал, байгууллагын чадавх

- Удирдах Зөвлөл /УЗ/ нийт 6 удаа хуралдаж, 17 шийдвэр гаргаснаас ихэнх буюу 90%-ийн биелэлттэй байна. Хяналтын Зөвлөл /ХЗ/ 2 удаа хуралдаж байгууллагын үйл ажиллагаа дүрмийн дагуу явагдаж байгаа эсэхэд хөндлөнгийн хяналт тавьж ажилласан байна. Шинэ УЗ, ХЗ-д зориулсан сургалтад холбогдох гишүүд, манлайллын сургалтад УЗ, ХЗ, бүлгийн ахлагч, манлайлагч гишүүд хамрагдсан.
- МЭИ-ийн ХХI Ерөнхий чуулганыг “Хамтдаа Ирээдүйнхээ Төлөө” уриан дор 6 дугаар сард анх удаа цахимаар зохион байгуулж, Эмнести Интернэшнлийн 60 жилийн ойг тэмдэглэсэн. Чуулганд 93 төлөөлөгч оролцож, Эмнести Интернэшнлийн Дэлхийн чуулганаар хэлэлцэх шийдвэрүүдэд МЭИ-ийн байр суурь, саналыг баталж, дүрмийн өөрчлөлтийг хэлэлцэн УЗ, ХЗ-ийн шинэ бүрэлдэхүүнийг сонгон батламжиллаа.

3. Гишүүн өргөжүүлэлт, чадавхжуулах

- Шинэ гишүүдэд байгууллагын үнэт зүйл, үйл ажиллагааны тухай ойлголтыг өгөх шинэ гишүүний сургалтыг цахимаар зохион байгуулж, гишүүдээ чадавхжуулан ажиллалаа.
- Бүлэг, гишүүдийн хүрээнд Ковид-19 ба хүүхдийн эрх, Ковид-19 ба уур амьсгалын өөрчлөлт, Ковид-19 ба Орон байртай байх эрх, Ковид-19 ба Үзэл санааны хоригдол, Технологи ба хүний эрх зэрэг бодлогын хэлэлцүүлгүүдийг зохион байгуулж, бодлого боловсруулахад болон гишүүдийн олон талт оролцоог ханган ажиллав.
- Сайн дурынханд МЭИ-ийн үйл ажиллагаанд цахим болон цахим бусаар ажиллах боломжийг бий болгож, менежмент сайтай ажилласныг үнэлж, биднийг Монголын Сайн дурын байгууллагуудын сүлжээнээс “2021 оны Шилдэг Сайн Дурын Байгууллага”-аар тодруулжээ.



4. Байгууллагын сайн сайхан байдал (Wellbeing)

- Байгууллагын сайн сайхан байдал буюу Wellbeing нь дөрвөн тулгуур ойлголт бөгөөд ажлын туршлагатай холбогдон бий болсон хувь хүний хэрэгцээг харуулдаг. Wellbeing-д бие махбод, сэтгэл хөдлөл, сэтгэлзүйн байдлыг л хамааруулан ойлгодог ч аюулгүй байдал, амьдралын баталгаа, ажиллах орчин, сэтгэл ханамж, ажлын зорилго, утга учир ба ажил дээрх сэтгэл зүйн эрүүл мэнд бүгд багтана. 2021 онд тусгай төлөвлөгөөний дагуу бид хүний эрхийн идэвхтэн, гишүүд, ажилтнууд, УЗ, ХЗ-ийн гишүүд, манлайлагч гишүүдийн сайн сайхан байдлыг хангах чиглэлээр ажиллав.
- Цар тахлын нөхцөл байдлаас үүдэн нийгмийн сэтгэл зүй хүнд үед Эмнести Интернэшнл гишүүд дэмжигчдийнхээ сэтгэл зүйн түгшүүр, стрессыг бууруулах зөв дадлыг бий болгохоор йогийн хичээлийг зохион байгууллаа.
- Бүх гишүүдийн уулзалтыг цахим, цахим бус хосолсон хэлбэрээр зохион байгуулж, “Нуугдсан эрхээ олцгооё” залуучуудын уулзалтаар Богд хан ууланд аялж, хөдөлмөрлөх эрхийн зөрчлийн талаар сургалт, хэлэлцүүлэг хийсэн.
- Эмнести Интернэшнлийн Сайн сайхан байдлын төлөвлөгөөний дагуу сайн дурынхан болон ажилтнууд ажилтай холбоотой бий болох эрсдэлийг үнэлж, зохицуулах арга хэмжээ авах чадвартай болсон төдийгүй амрах, эрч хүчээ сэлбэхэд цаг хугацаа зарцуулдаг болжээ.



205

Сайн дурын ажилтан



10,473 цаг

Хүний эрхийн төлөө зарцуулжээ.

Бид 2021 онд оролцоотой, олон талт, шилдэг сайн дурын менежменттэй, стресс бухимдалгүй, илүү олон идэвхтэн, дэмжигчдийг дайчилсан байгууллага боллоо.

ЭМНЕСТИГИЙН ЗАЛУУЧУУД

Зорилт.1 Эмнести Интернэшнлийн хүний эрхийг хамгаалах ажлын гол төвд залуучуудын үзэл санаа, байр суурийг тусгах

- Манлайлагч гишүүдийн 6 удаагийн уулзалт зохион байгуулж, залуус Монголын Эмнести Интернэшнлийн стратеги, бодлогыг хэлэлцэж, цаашид хийх ажлаа төлөвлөлөө. Залуус үзэл санаагаа чөлөөтэй илэрхийлж, хүний эрхийн төлөөх үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах чадвартай болсон байна.
- Дэлхийн хүүхэд, залуучуудын 2022-2025 оны стратегийг хэлэлцэх уулзалтыг зохион байгуулж, стратегийг хэрхэн сайжруулах, хэрхэн Монгол улсад хэрэгжүүлэх талаар хэлэлцэж, төлөвлөгөө боловсрууллаа.
- 2021 онд Монголын Эмнести Интернэшнлийн удирдах зөвлөлд 18-24 насны 1 залуу гишүүн, хяналтын зөвлөлд 2 залуу гишүүн сонгогдож, залуучуудын дуу хоолойг шийдвэр гаргах түвшинд хүргэж байна.

Зорилт.2 Залуус Эмнести Интернэшнлийн үйл ажиллагааны бүх түвшинд идэвхтэй, манлайлан оролцох бололцоог хангах

- Залуус "Нөхөрсөг жаалууд" сургалт, "Эмнести Пресс" цахим сонин, "Нууц шүү за" цахим аян, "Эрхийнхээ төлөө бичигцгээ", "КОВИД-19-ийн эсрэг хамтдаа" захидал бичих аян зэргийг манлайлан зохион байгууллаа.
- "Хүний эрх энгийн үгээр" 6 удаагийн цуврал сургалтаар 150 гаруй залуу гишүүн хүний эрхийн мэдлэгээ өргөжүүлсэн байна.




- "Залуусын сайн сайхан байдал" чөлөөт уулзалт, "Таагүй мэдрэмжээ даван туулах нь" сургалтуудыг зохион байгуулж, залуучуудын цар тахалтай холбоотойгоор үүсэх стресс, сэтгэл зүйн асуудлыг бууруулах, залуу активистуудын сайн сайхан байдлыг анхаарч, тэднийг аюулгүй орчинд хүний эрхийн үйл ажиллагаа явуулах боломжийг хангахад анхаарлаа.
- Эмнести Интернэшнлийн олон улсын төвөөс зохион байгуулсан Дэлхийн активизмын туршлага хуваалцах семинарт Монгол улсаа төлөөлөн 5 залуу идэвхтэн оролцлоо. Орон орны залуус амжилттай өрнүүлсэн хүний эрхийн активизм, үйл ажиллагаагаа ярилцаж, туршлагаа хуваалцав. Монголын залуусын "Эх хэлээ аваръя" активизм шилдэгээр шалгарч, үр дүн, амжилтаа танилцуулсан нь бахархам амжилтын нэг байлаа.
- Эмнестигийн залуу гишүүдийг идэвхжүүлэх зорилгоор "Эмнестигийн залуусын цаг" цахим чөлөөт уулзалтыг санаачилж, зохион байгууллаа.

Зорилт.3 Эмнести Интернэшнлийн дэмжигчдийн 1/3-ыг залуу гишүүд бүрдүүлж, хүний эрхийн өөрчлөлт авчрах гол хүч болох

- МЭИ-ийн залуус "Sweet September", "Ярьдаг футболк" зэрэг гишүүн өргөжүүлэх аяныг амжилттай зохион байгуулж, үе тэнгийнхнийгээ хүний эрхийн үйлсэд нэгдэхийг уриаллаа.
- МЭИ-ийн гишүүд дэмжигчдийн 2/3 буюу 67%-ийг залуу гишүүд бүрдүүлж, үйл ажиллагааны бүх түвшинд манлайлан оролцож байна.

Бусад гишүүд
34%



Залуу гишүүд
66%

ХҮНИЙ ЭРХИЙН АКТИВИЗМ

Дотоодод

- Эмч, эмнэлгийн ажилтнуудын эрхийг хамгаалах активизмыг өрнүүлж, Монголын Эмнести Интернэшнлийн Эрүүл мэндийн яаманд хүргүүлсэн эмч, эмнэлгийн ажилчдын ажиллах таатай орчныг бүрдүүлэх шаардлагыг бүрэн хэрэгжүүлэхийг уриаллаа.
- Тэгш эрх бахархлын өдрүүдэд Эмнести Интернэшнлийн залуус нэгдэж, эв нэгдлээ илэрхийллээ.
- Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлд орсон зарчмын зөрчилтэй заалтыг өөрчлөх уриалгыг явуулж, цахим давлагаа өрнүүлсэн байна.
- Олон улсын хүний эрхийн өдрийг угтан Хүний эрхийн форумаас зохион байгуулсан “Эрхээ шаардъя” цахим аянд нэгдэж, Эмнестигийн цахим идэвхтнүүд манлайлан бичлэг, контент бэлтгэсэн байна.
- “Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай” хуулийн төсөлд тусгагдсан хүний эрхийг зөрчсөн заалтуудыг өөрчлөхийг шаардсан цахим аяныг өрнүүлээ.



Олон улсад

- “Гэм зэм” жүжгийн үеэр Гана улсад цаазаар авах ялыг халах активизм өрнүүлж, тус улсын засгийн газарт хүргүүлсэн захидалд гарын үсгээ цуглуулж, нэгдлээ.
- Хүн бүрийг вакцинд тэгш хамруулах боломж олгохыг эмийн үйлдвэрүүдээс болон их 20-ийн улсын удирдагчдаас шаардах цахим активизм өрнүүлсэн.
- Фэйсбүүк болон Гүүглээс тандалтад суурилсан сурталчилгаагаа зогсоохыг шаардсан цахим активизм өрнүүлж, залуус цахим уриалга явууллаа.
- Катарын цагаач ажилчдын хөдөлмөрлөх эрхийг хамгаалахыг Дэлхийн хөл бөмбөгийн холбооноос шаардаж, цахим болон цахим бус активизм өрнүүлсэн.
- Турк улсыг Истанбулын хэлэлцээрээс гарах тухай шийдвэрээ эргэн харж, охид, эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалахыг шаардлаа.
- Хятадын үндэсний цөөнх Уйгур иргэдийн эрхийг хамгаалах цахим активизм өрнүүлж, олон нийтийг уриаллаа.

Хүний эрхийг хамгаалахыг шаардсан үйл ажиллагаанд нийтдээ




25,000

гаруй хүн хүний эрхийн активизмд нэгджээ.

2021 оны санхүүгийн хураангуй тайлан

САЛБАР: МОНГОЛЫН ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ

САНХҮҮЖИЛТ 2021		2021 оны 1 сарын 01-нээс 12 сарын 31	2021 оны 1 сарын 01-нээс 12 сарын 31
		Төсөв (ам. доллар)	Гүйцэтгэл (ам. доллар)
Гишүүдийн татвар, хандивын тогтмол төлөлт		3,750.00	1,193.73
Тогтмол бус хандив		4,000.00	1,200.51
Тэтгэлэг олгогчийн санхүүжилт		28,860.00	20,850.49
Бусад сан арвижуулалт		20,056.00	2,120.82
Гаднаас олсон нийт орлогын дүн		56,666.00	25,365.55
ОУТөвийн санхүүжилт		167,130.00	171,715.00
НИЙТ САНХҮҮЖИЛТ		223,796.00	197,080.55
ЗАРЦУУЛАЛТ 2021			
Хүний эрхийн стратегийн зорилт	Зорилго 1 - 4	122,237.66	87,239.55
Өсөлтийн стратегийн зорилт	Зорилго 5 - Сан арвижуулах	10,535.00	9,205.88
Зорилго 5	Зорилго 5- Бусад асуудал	27,732.81	24,684.15
Стратегийн зорилгоос гаднах хүний эрхийн үйл ажиллагаа		15,743.80	16,896.85
Удирдлага, дотоод ардчилал болон бусад дэмжих ажиллагааны зардал		47,546.73	66,061.49
НИЙТ ЗАРДАЛ		223,796.00	204,087.92
Эхний үлдэгдэл			
Бэлэн мөнгө [кас ба банк]		55,520.79	
Нөөц сан		85,474.74	
Урьдчилж төлсөн төлбөр		5,882.99	
Авлага		4,151.61	
Өглөг		8,454.96	
Эцсийн үлдэгдэл			
Бэлэн мөнгө [кас ба банк]			57,158.82
Нөөц сан			75,638.74
Урьдчилж төлсөн төлбөр			4,566.53
Авлага			40,885.36
Өглөг			42,681.65



Хянасан гүйцэтгэх захирал:

Б. Алтантуяа

Тайланг боловсруулсан ня-бо:

У.Наранцацрал

Аудит хийсэн Аудитор:

О. Чулуунбаатар /Эс-Эм Аудит ХХК/



БҮХ ЗҮЙЛ ТАНААС ЭХЭЛДЭГ

ТАНЫ ТӨЛСӨН ТАТВАР, ХАНДИВ, ХУДАЛДАН АВАЛТ ДАРААХ ЗҮЙЛСЭД ЗАРЦУУЛАГДДАГ.



ҮҮНИЙ ҮР ДҮНД БИД:



ӨГӨӨМӨР ДЭМЖИГЧИД

Эмнести Интернэшнл судалгаа, кампанит ажлуудаараа бусдад танигдсан хэдий ч өгөөмөр дэмжигчидгүйгээр энэ бүхнийг хийх боломжгүй юм.

Хандивласан хөрөнгө нь манай байгууллагын дараах кампанит ажилд хувь нэмэр орууллаа.

- Хүний эрхийн боловсрол
- «Эрүүдэн шүүхийн эсрэг» кампанит ажил
- «Шаардлагад нийцсэн орон байртай байх эрх» кампанит ажил

ХҮНИЙ ЭРХЭД хувь нэмрээ ОРУУЛАХ ҮНЭХЭЭР АМАРХАН

Хүний эрхийн төлөө тэмцэнэ гэдэг нь та заавал гудамжинд уриа лоозон барьж жагсана гэсэн үг биш. Эмнести Интернэшнлийн үйл ажиллагааг дэмжиж гишүүн болох, мөнгө хандивлах зэрэг нь дэлхий дахинд хүний эрх, шударга ёс авчрахын төлөө таны оруулж буй хувь нэмэр юм.

Та WWW.AMNESTY.MN цахим хуудсаар зочлон бидний хийж буй хүний эрхийн төлөөх ажлуудтай танилцан доорх дансаар мөнгө хандивлаж болно.

Голомт банк: 112098352





Хаан банк:
₮ данс

2021 оны хандивлагчид /мөнгөн, мөнгөн бус/:

- Монгол даатгал ХК
- Орфей театр фильм
- Смарт Медиа Дизайн ХХК



2021 ОНД ХЭВЛЭСЭН НОМ ТОВХИМОЛ





ЯАСАН ХАРАНХУЙ НОМ БЭЭ?
ГЭЖ ХАШХИРСНААС
ЯДАЖ ТА ӨӨРӨӨ
НЭГ ЧГЭСЭН ЛАА АСАА



ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЭЛ АВАХЫГ ХҮСВЭЛ:



70004705



www.amnesty.mn



Amnesty International Mongolia
Монголын Эмнести Интернэшнл



Amnesty International Mongolia



Members@amnesty.mn



Сүхбаатар дүүрэг, 6-р хороо,
Их сургуулийн гудамж, #AB
центрийн 11 давхарт 1101 тоот